



## Бурхан бол бидний Зөвлөгч Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар: Бурхан бол бидний Зөвлөгч**

**Attribute: God Is Our Counselor**

**Тодорхойлолт:** Зөвлөгөө өгдөг, удирдамж ба чиглүүлэг өгдөг Нэгэн.

**Эшлэл(үүд):**

- **Дуулал 119:24** Таны гэрчлэлүүд мөн миний баясал, Миний зөвлөгчид юм.
- **Иохан 14:16-17** Би Эцэгээс гуйхад Тэр та нарт өөр туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний сүнс бөгөөд Түүнийг харахгүй мэдэхгүйгээсээ ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Тэр та нартай хамт байх бөгөөд та нарын дотор байх тул та нар Түүнийг мэднэ.
- **Иохан 14:25-26** Би та нартай хамт байхдаа үүнийг хэллээ. Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүгдийг заах бөгөөд та нарт хэлсэн бүгдийг минь сануулах болно.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.* 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн.* 1 Тесалоник 5:18

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Дуулал 16:7-8

**Библийн эшлэлээр залбирах:**

*Надад зөвлөдөг ЭЗЭНийг би магтана; шөнөөр ч оюун бодол минь сургадаг. ЭЗЭН өмнө минь үргэлж байсан. Тэр миний баруун талд байдаг учраас Би ганхахгүй” хэмээн (Хүүхдийн нэр) итгэл дүүрэн хэлэх болтугай.*

**Залбирлын тодорхой хүсэлт**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- *Надад зөвлөдөг ЭЗЭНийг би магтана; шөнөөр ч оюун бодол минь сургадаг. ЭЗЭН өмнө минь үргэлж байсан. Тэр миний баруун талд байдаг учраас Би ганхахгүй” хэмээн \_\_\_\_\_ итгэл дүүрэн хэлэх болтугай. Дуулал 16:7-8*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

*Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!*